

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЕСӨНЗҮЙЛ СУМ



**ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГГИЖ БУЙ
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

МӨНХБУЛАГ
2024 ОН

ᠡᠰᠦᠨᠵᠦᠢᠯ ᠰᠤᠮᠤᠨᠳ ᠬᠡᠷᠡᠭᠭᠢᠵᠢᠵ ᠪᠤᠢ
ᠲᠣᠭᠲᠣᠤᠯ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠭᠢᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ
ᠲᠥᠨᠲᠤ ᠣᠨᠤ ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠡᠴᠰᠢᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ

ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧ ТАЙЛАН

2024.12.16

Есөнзүйл сум

Тус сум нь 2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хууль 7, Ерөнхийлөгчийн зарлиг 3, Улсын Их хурлын тогтоол 3, Монгол улсын Засгийн газрын тогтоол 58, Засгийн газрын албан даалгавар 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 6, нийтдээ 72 тогтоол шийдвэрийг хяналтдаа авч хувийн хэргийг нээн холбогдох албан хаагчид танилцуулан биелэлтийг ханган ажиллаж байна.

Тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргахад Монгол улсын хууль 100%-ийн биелэлттэй, Монгол улсын Улсын Их хурлын тогтоол 96,6%-ийн биелэлттэй, Ерөнхийлөгчийн зарлиг 100%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын тогтоол 96,1%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын албан даалгавар 96,3%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 94,2%-ийн биелэлттэй байна. Мөн нийт тогтоол шийдвэрийн хувьд 100 хувь биелэлттэй 7 хууль, Улсын Их Хурлын тогтоол 2, Засгийн газрын тогтоол 41, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, Засгийн газрын албан даалгавар 9 заалт буюу нийт 100 хувийн биелэлттэй 62 заалт, 90 хувь биелэлттэй Улсын Их хурлын тогтоол 1, Засгийн газрын тогтоол 13, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 4, Засгийн газрын албан даалгавраас 1 заалт буюу нийт 19 зүйл заалт байна. Мөн 70 хувийн биелэлттэй Засгийн газрын тогтоол 3 зүйл заалт, Засгийн газрын албан даалгавраас 1 буюу нийт 4 зүйл заалт байна. Нийт 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн биелэлт 97,2 хувьтай биелээд байна.

Тогтоолын биелэлтийг ханган ажилласны үр дүнд:

Монгол улсын хууль: Хөдөлмөрийн тухай хуулийг төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцэж гарсан Засгийн газрын тогтоол, төрийн албаны зөвлөлийн тогтоол зэрэг холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон ажиллалаа. Хөдөлмөрийн тухай хуулиас хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх, ажилтан болон ажил олгогчийн эрх үүргүүдийг байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн албан байгууллага тус бүр дотоод журмыг шинэчлэн болон шинээр боловсруулан мөрдөн хэрэгжилтийг нь хангаад байна.

Монгол улсын Улсын Их Хурлын тогтоол: Жил бүрийн төсөвт төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг тусган хууль тогтоомжийн дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын


зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна.

Ерөнхийлөгчийн зарлиг: “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тохижилт үйлчилгээний ажилчдыг мод услахад зориулан портер машин, усалгааны сав, усны помп зэргийг авч өгөн тоног төхөөрөмжөөр ханган мод үржүүлэх ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Есөнзүйл сумын Засаг даргын захирамжаар “Батцэцэрлэгжилт” ХХК-д 15 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар олгож талбайд мод үржүүлгийн газар шинээр бий болон 2024 онд үрслэгээний 100000 мод ойн зурвас байгуулан 5000 мод тарьсан байна. Мөн 2024 онд сумын хэмжээнд нийт 20450 мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан байна. Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан бут, сөөг, цэцэг тарих цаашид хамгаалах түүнийгээ амьдралын хэв маяг болгох талаар төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн цахим хэлбэрээр иргэдэд хэрэгтэй заавар зөвлөгөө, зөвлөмжийг цаг тухай бүрд нь хүргэн ажиллаж байна. Сумын төрийн байгууллага, аж ахуй нэгж, айл өрхүүд нийт бургас-183, улиас-224, хайлаас-172 мод тарьж, цэцгийн мандал байгуулсан. Энэхүү бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт маань бидний хойч ирээдүй болсон Ерөнхий Боловсролын Сургуулийн төгсөх ангийн хүүхдүүд маань нэгдэж төрөлх сургуульдаа 50 ширхэг улиасыг тарьсан. 2024 онд бургас, хайлаас, улиас, чацаргана, үхрийн нүд нийт 20450 мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн Бүх нийтээр мод тарих өдрүүд эхэлж байгаатай холбоотойгоор 05 дугаар сарын 07-нд Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, ТҮК-ийн ажилтан Э.Батсүх нарын хамт ‘Өндөр Гэгээн Занабазарын Номын Өргөө’ цэцэрлэгт хүрээлэн, Мөнхбулагийн 2-р багийн Фонд баруун, зүүн, хойд талын хашаалж тарьсан талбайн бургас, улиас, шинэс модонд тандалт, тайралт хийж, орчны хог хаягдыг цэвэрлэж, нөхөн тарилт хийж, цэнэг усалгааг 14 хоногт 2 удаа хийж гүйцэтгэн ажилласан байна.

Засгийн газрын тогтоол: 2024 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 505 өргөдөл хүлээн авч үүнээс 488 өргөдлийг шийдвэрлэн хугацаа болоогүй 17 өргөдлийг шийдвэрлэх шатанд явж байна. 2024 онд өргөдлийг 96,6% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүдийн 97% бичгээр, үлдсэн 3 хувь цахимаар ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэн ажиллалаа. 2024 онд ирүүлсэн өргөдлүүдээс хамгийн их буюу 235 ирүүлсэн буюу нийт өргөдлийн 46,53%-г эзэлж байна. Мөн нийгмийн даатгалтай холбоотой өргөдөл 88, газар өмчлөх тухай хүсэлт өвөлжөө хаваржааны газар хүссэн өргөдөл нийт 58, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах талаарх өргөдөл 75, ажилд орох, чөлөөлүүлэхтэй холбоотой өргөдөл 32, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 0, хүлэмж хүссэн 3, Жирэмсний амралт хүссэн 2, чөлөө олгох 2, бусад агуулгаар 9 өргөдөл тус тус ирж шийдвэрлэн ажилласнаас нийт газар хүссэн 17 өргөдлийн хугацаа болоогүй байна. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажилласан. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд

гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна.

ХЯНАСАН: ДСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА  Ц.МЯГМАРСҮРЭН

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Т.МӨНХЗУЛ